



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 5/84

Хэрлэн сум

П.Эрдэнэчимэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.8, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны 354, 2014 оны 208 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/3243 дугаар албан бичгийн дагуу аймгийн Нийтийн номын сангийн захирлын сул орон тоонд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны шаардлага хангасан Пельчирийн Эрдэнэчимэгийг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Аймгийн Нийтийн номын сангийн захирлын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг П.Эрдэнэчимэгт үүрэг болгосугай.

3. П.Эрдэнэчимэгийн үндсэн цалинг ТҮСҮ-8-1 шатлалаар 622878 /зургаан зуун хорин хоёр мянга найман зуун далан найм/ төгрөгөөр тогтоож олгохыг Нийтийн номын сангийн нягтлан бодогч /Ш.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. П.Эрдэнэчимэгт томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА